

## Бодлого, төлөвлөлтийн газар

Газар, хэлтсийн нэр	Үндсэн чиг үүрэг
<b>2. Бодлого, төлөвлөлтийн газар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн /цаашид бүхэлд нь “салбарын” гэх/ талаар баримтлах бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх;</li> <li>• салбарын бодлогыг төрөөс баримтлах бодлого болон бусад салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах;</li> <li>• салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, нийгэм, эдийн засгийн үр ашгийн тооцоолол хийх, ТЭЗҮ, төслийн санал боловсруулах ажлыг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах;</li> <li>• салбарын шинжлэх ухаан, техник, технологийн дэвшилтэт арга, инноваци, технологийн ололтыг бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрт тусгуулах, баримт бичгийн боловсруулалтын чанарыг зураг төслөөр дамжуулан боловсронгуй болгоход мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> <li>• салбарын норм, нормативын тогтолцоог бүрдүүлэх, олон улсын стандарт, норм нормативын баримт бичгийг өөрийн оронд нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг зохион байгуулах, батлуулах, норм, нормативыг сурталчлах;</li> <li>• барилга байгууламжийн норм, нормативын санг бүрдүүлэх, зарцуулах болон сангийн үйл ажиллагааг бодлогын удирдамж, чиглэлээр хангах;</li> <li>• төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааг салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулах, хамтран ажиллах, салбар дундын зохицуулалтыг хангах;</li> <li>• салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг батлуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</li> <li>• Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн орон сууцны бодлогыг төлөвлөх, үе шаттайгаар хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах;</li> <li>• газрыг хөгжүүлэх, инженерийн дэд бүтцээр хангах, барилгажуулах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын уялдааг сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх;</li> </ul>
<b>2.1. Орон сууц, санхүүжилтийн хэлтэс</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон сууцны салбарын тогтолцоо, иргэдийг орон сууцжуулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</li> <li>• төрөөс хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулж, хэрэгжилтийг ажлыг зохион байгуулах;</li> <li>• ипотекийн зээл, түрээсийн орон сууцны тогтолцоог сайжруулах, хэрэгжилтийг хангуулах;</li> <li>• гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд зорилтод бүлгийг орон сууцжуулах санал боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>• эрчим хүчний хэмнэлттэй, олон улсын байгууллагуудын хүлээн зөвшөөрсөн орон сууцыг барих асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, удирдлага арга зүйгээр хангах;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• орон сууцны тогтолцоонд оролцогч байгууллагуудын харилцан уялдааг хангуулах.</li> </ul>
<p style="text-align: center;"><b>2.2. Гадаад хамтын ажиллаганы хэлтэс</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Гадаад хамтын ажиллагааны бодлого, чиглэлийг салбарын үйл ажиллагааны стратегитай уялдуулан тодорхойлох, хамтын ажиллагааг өргөжүүлэх хөгжүүлэх, удирдан зохион байгуулах, төлөвлөгөө гаргах;</li> <li>• салбарын гадаад хамтын ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, гадаад арга хэмжээ, чиглэлийг нэг цонхны бодлогын хүрээнд баримтлан нэгдсэн байдлаар зохион байгуулж, хариуцан ажиллах;</li> <li>• Засгийн газар хоорондын комиссын хуралдаанууд, зөвлөлдөх болон дугуй ширээний уулзалтууд, дээд, өндөр түвшний айлчлалууд, стратегийн түншлэлийн хөтөлбөр, хамтын ажиллагааны урт, дунд хугацааны хөтөлбөрүүд, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр зэрэг хоёр болон олон тал хамтын ажиллагааны механизмуудад салбарын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийн саналыг тухай бүрт оруулан хэлэлцүүлэх, тусгуулах, гэрээ хийгдэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</li> <li>• хоёр болон олон талт хамтын ажиллагааг салбарын стратегитай уялдуулан хөгжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгдсэн байдлаар холбогдох байгууллагуудад хүргүүлж, хөрөнгө оруулалт татах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</li> <li>• төсөл, хөтөлбөрийн тусгайлсан гэрээ, хэлэлцээр байгуулах шат хүртэлх бэлтгэл ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулж, хариуцан ажиллах;</li> <li>• яам, харъяа байгууллагуудын удирдлагуудын айлчлал, протокол, уулзалтууд, албан хаагчдыг гадаад томилолтыг нэгдсэн байдлаар зохион байгуулах.</li> </ul>